

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН МАНАНТ ХӨНДИЙН ХАДНЫ ЗУРГИЙН ДҮР ДҮРСЛЭЛИЙН АСУУДАЛД

Г. Золбаяр^{1,*}

Товч агуулга: Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Манант хөндийд илэрсэн хадны зураг бүхий нэгэн хавтанг энэхүү өгүүлэлд нийтэлж байна. Уг хавтан дээр 19 танигдахуйц дүрс байгаа бөгөөд тэдгээрийн дотор сүрлэг том, үзүүр нь гадагшаа махийсан эвэртэй үхрийн дүрс давамгайлах юм. Уг хавтан дээр илэрхий харагдахуйц “зам” юм уу “хил зааг” гэж нэрлэж болох зураасыг татсан нь онцлог сонирхолтой дүрслэл болно.

Түлхүүр үг: Хадны зураг, зураг бүхий хавтан, үхэр, Монгол Алтай

Удиртгал

Манант хөндий /Шуй ашы/ хэмээн нэрлэдэг жижигхэн чулуун толгой бол аймгийн төв Өлгий хотоос 25 км, Өлгий-Улаанхус сумын замын дагууд, төв замаас 1,9 км газарт байрладаг хадархаг толгойн энгэрт байрласан намхан хөтлийн дэргэд байдаг. Газар зүйн байрлал нь: 49.014209° 89.640978°, дтд 2020 м. Хүрэн өнгөтэй занар чулуугаар бүтсэн энэ толгойн энгэрт газраас 20-30 см өндөртэй 7х4 м харьцаатай хавтгай чулуун дээр дээшээ харсан байрлалтай зургууд байна. Уг зурагт хавтангийн эргэн тойронд өөр хадны зураг байхгүй. Уг зургуудыг одоогоор археологийн бүртгэл судалгаанд хараахан ороогүй болохыг лавлан үзээд миний бие энэхүү өгүүллийг нийтэлж судалгааны эргэлтэд оруулахыг зорив.

Зургуудын тодорхойлолт

Манант хөндийн хадны зураг бүхий хавтгай хадан дээр том жижиг нийт 19 дүрслэл сийлсэн байна (Зураг 1). Эдгээрийн дотор нийт 13 үхрийн дүрс, 2 янгир чухам юуны дүрс гэдэг нь тодорхойгүй 3 амьтны дүрс, “ангийн зэвсэг” байж болохуйц нэгэн дүрслэл, мөн нэг нохойн дүрслэл байна. Нийт сэдвээр нь аваад үзвэл ихэнх нь үхрийн дүр дүрслэл бөгөөд бүхэлд нь уг зурагт хавтанг “Үхрийн хавтан” гэж нэрлэж болохоор юм. Мөн зургуудын доод талд хэвтээ тэнхлэгээр явсан зураас баруун гар талд босоо тэнхлэгээр татагдсан байх төдийгүй зургуудын төв хэсэгт гурван амьтныг холбосон өөр нэгэн салаа ирж нийлж байна. Монгол Алтайн хадны зургийн дотор ховорхон энэхүү дүрслэл Манантын хөндийн зурагт хавтанг онцгой болгож байгаа билээ.

Энд хоёр ширхэг янгирын дүрс байгаа нь тод

харагдаж байна. Тодруулбал, 5-р зурагт нэгэн үхрийг сийлсэн боловч хожим дээр нь давхардуулан нэгэн янгир сийлсэн тул уг янгирын дүрс нилээд хожуу үеийн дүрс гэдэг нь тодорхой бөгөөд сийлсэн техникийн хувьд ч бусад дүрснүүдээс ялгаатай юм. Энд сийлсэн үхрүүд нилээд өвөрмөц байдлаар сийлэгдсэн байна.

Доор зурагт хавтангийн гар зургийг схемчлэн сийрүүлж буулгаад (Зураг 2) дүрс бүрийг ширхэгчлэн тодорхойлов.

Дүрс 1. Үл танигдах нэгэн амьтны дүрс (хирс маягийн амьтан).

Дүрс 2. Энд сүүлээ дээш годойлгон өргөсөн урт эвэртэй үхрийн зураг байна. Энэхүү зургийг үзэхэд томхон эвэр дэлдгэр чих зэргээр нь үхэр гэж танигдаж байгаа боловч сүүлээ дээш нь эгц өргөсөн байдлаар дүрсэлжээ.

Дүрс 3. Энэ зурагт мөн томоохон эвэртэй нэгэн амьтаныг доош нь харуулж сийлсэн байна.

Дүрс 4. Томоохон үхрийг эврийг нь үзүүр хэсгээр махийлган дүрсэлжээ. Тэгш талбайд хонхойлгон сийлж үхрийн дүрийг тод томруун гаргасан байна. Үхрийн эврийн үзүүр хэсгийг дээш нь матийлган томоохон дугуй хэлбэртэй болгож сийлсэн бөгөөд үхрийн биеийн хэсгийг тэгш хэмийн зарчмын дагуу 12 хэсэгт хувааж дүрсэлж өгснөөрөө онцгой байна.

Дүрс 5. Энэ зурагт үхрийн бүтэн биеийг дүрсэлсэн боловч хожим нь дээр нь давхардуулан нэгэн янгирыг дүрсэлсэн тул зургийн эх хувилбар нь нилээд өөрчлөгдсөн байна. Нэгэн дунд зэргийн үхрийг эврийн үзүүр хэсгийг матийлган дүрсэлсэн боловч цээжин хэсэг нь янгирын дүрс давхардуулан сийлсэнээр зургийн байдал нилээд өөрчлөгдсөн байна. Харин үхрийн сүүл хэсэг нь тодорхой сайн гарсан бөгөөд мөн л тэгш хэмийн аргаар дөрвөлжин талбай хуваан эрээлж сийлсэн нь мэдэгдэж байна.

Дүрс 6. Энэ хавтан дээрх хамгийн том үхрийн дүрснүүдийн нэгийг сийлэхдээ хөвөөлөн цохиж их биеийн хэсгүүдийг тэгш хэмийн аргаар дүрсэлснээс

¹ ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Баян-Өлгий аймаг дахь салбар

* Холбоо барих зохилт: zolbayargagaa@yahoo.com

гадна томоохон эврийг нь дүрсэлсэн байна. Энэ үхрийн эврийн үзүүр хэсгийг матийлгаагүй шууд дугуй хэлбэрээр дүрсэлсэн нь онцлог байна. Үхрийн их биеийг дээрх хоёр үхрийн нэгэн адил тэгш хэмийн аргаар олон жижиг хэсэгт хувааж дүрсэлжээ.

Дүрс 7. Нэгэн үхрийг тусгайлан нүхэнд унаснаар юм уу эсвэл хашаанд хорьсон байдлаар бусдаас ялган салангид дүрсэлсэн байна. Гэхдээ зургийн үндсэн зохиомжийн шулуун зураастай богино зураасаар холбож бусад дүрсүүдтэй холбоотой гэдгийг харуулжээ. Энд уг үхрийн их биеийн байдал алдагдаагүй толгойгоо эсрэг зүгт хандуулж дүрсэлжээ.

Дүрс 8. Эврийн хэсгийг хойш нь махийлган дүрсэлсэн үхрийн дүрс бөгөөд их бие нь бүрэн гарсан байна. Зургийн онцлог нь уг үхрийн зогдор хэсгийг товойлгон гаргасан байна.

Дүрс 9. Нэгэн үхрийг эврийг нь дээрээс доош тахийлган үзүүрийг нь толгойн хэсэгтэй холбон зурсан байна. Жижгэвтэр үхэр боловч эврийг нь битүү гогцооруулан дүрсэлсэн бөгөөд сүүлийг нь ташуу гаргаж хөлийг нь урт болгон дүрсэлжээ.

Дүрс 10. Нэгэн жижигхэн амьтны сүүл чихийг нь дүрслэн гаргажээ. Мөн Дүрс 12-той зураасаар холбосон байна.

Дүрс 11. Нэгэн үхрийг цааш харсан байдалтай дүрсэлсэн байна.

Дүрс 12. Эврийг нь махийлган дүрсэлсэн томхон үхрийн зураг байна. Энэ бол зурагт хавтан дээрх хамгийн том амьтны дүрслэл юм. Зургийн онцлог нь үхрийн чихийг нилээд дэлдийлгэн зурсан байна.

Эврийн үзүүрийг дээш махийлган толгойн хэсэгтэй холбосон нь онцгой байна.

Дүрс 13. Энэ зурагт нэгэн зүйлийн зэвсгийг дүрсэлсэн бололтой байна. Хадны зураг судлаач доктор Х.Едилхан ан амьтдыг нүхэнд унагаах нэгэн зүйл зэвсэг байсныг дурдаад уг зэвсгийг “абак зэвсэг” гэж эртний казахууд нэрлэдэг байсан тухай докторын ажилдаа дурдсан байна (Едилхан 2009).

Дүрс 14. Нэгэн жижигхэн янгир дүрсэлсэн бөгөөд энэ нь хожим сийлсэн гэдэг нь дүр дүрслэл, олон томоохон үхрийн дунд оруулж дүрслэсэн гэдгээрээ ялгарч байна.

Дүрс 15. Томоохон үхрийг эврийг нь матийлган дүрсэлсэн байна. Эврийг урт гаргаж үзүүр хэсгийг матийлгаж дүрслэн 2 чихийг гаргаж дүрсэлсэн нь сонирхолтой. Үхрийн дүрсийг Дүрс 10-12-р зургуудтай холбосон нь анхаарал татаж байна.

Дүрс 16. Жижгэвтэр үхрийг баруун хойш харсанаар дүрсэлсэн бөгөөд сүүлийг нь харахад үхэр гэдэг нь тодорхой бөгөөд эврийг нь арай жижигээр дүрсэлсэн байна.


Дүрс 17. Хойт зүг рүү харж байгаа нохойг дүрсэлсэн болов уу гэж харагдахаар дүрслэл байна.

Дүрс 18. Зүүн хойт зүг рүү харсан эвэртэй үхрийг дүрсэлжээ. Дүрслэлийн хувьд онцгой зүйлгүй, цээжин хэсэг нь бадриун сүүл хэсэг нь шувтандуу.

Дүрс 19. Томоохон үхрийг зүүн зүг рүү харуулан дүрсэлсэн байна. Эвэр нь бусад үхрүүдийг бодвол үзүүр нь гадагшаа матийгаагүй тэгшхэн сайхан жигд дотогшоо матийжээ.




Зураг 1. Манант хөндийн хадны зураг бүхий хавтгай хад



Зураг 2. Манант хөндийн хадны зураг бүхий хавтангийн схемчилсэн гар хуулга (Золбаяр 2021)

Хүснэгт 1. Манант хөндийн зурагт хавтангийн дүрсүүд

 Дүрс 1	 Дүрс 2	 Дүрс 3
 Дүрс 4	 Дүрс 5	 Дүрс 6



Зургуудыг дундуур нь зураас гарган хил юм уу зам маягийн зүйлээр заагласан ба 7-р зурагт 1 үхрийг ганцаарчлан авч нүх маягийн зүйлд оруулан дүрсэлсэн байна. Бүх зургуудыг нэгэн хавтгайд дүрсэлж 7-р зургийн үхрийг ганцаарчлан дүрсэлсэн бөгөөд 8-р үхэр болон 2, 3-р үхрийг гортигоос гарган дүрсэлжээ. Мөн 11, 12, 15-р үхрийг холбон дүрсэлжээ. Энэ нь зураасаар холбох аргыг ашигласан дүрслэл юм.

Хэлэлцүүлэг

Манант хөндийн зургуудыг Монголын хадны зургийн ихэнхийн адилаар “хаднаа хонхойлгон дүрслэх аргаар дүрсэлсэн боловч дотроо амьтдын дүрийг бүх талбайгаар нь хонхойлгон цохих, зарим зургийн зөвхөн гадаад тэгийг хөвөөлөн цохиж доторхи орон зайг хөндөлгүй товгор хэвээр үлдээх аргыг хэрэглэсний” (Цэвээндорж 2009) зэрэгцээ энэхүү хадны зурагт тухайн амьтны зарим хэсгийг цоохорлон

сийлбэрлэсэн байгаа нь онцлог юм. Ийм хэлбэрийн зургуудыг НТӨ III-I мянганд урласан гэдгийг Д.Цэвээндорж цохон тэмдэглээд “чулуун зэвсгийн үед амьдарч байсан хүмүүс хадны зургийг бүтээж үлдээв үү гэдэг асуудал Төв Азийн археологчидын анхаарлыг татсаар ирсэн маргаантай хурцхан асуудлын нэг” (Кубарев и др. 2009) тул цааш цаашдын судлаачид он цагийн асуудалд илүү их анхаарна биз ээ.

Энэхүү хадны зураг нь тэгш хадан гадаргуу дээр хонхойлгох аргаар хадан дээр сийлсэн тун өвөрмөц зураг юм. Зарим зураг дээр тухайлбал 4, 5, 6-р зураг дээр байгаа үхрүүдийг тэгш хэмийн аргаар их биеийг дөрвөлжлөн зурсан нь онцгой байна.

Бүх үхрийг баруун тийш харснаар дүрсэлсэн нь онцлог болжээ. Харин өөр цаг үед зурагдсан болов уу гэмээр 5, 14-р зургуудад дүрслэгдсэн 2 янгирын дүрсийг зүүн тийш харуулж дүрсэлжээ. Иймд энэ хадны зураг нь хоёр өөр үед хоёр тийш харуулж дүрсэлсэн дүрслэл байна гэж үзэв.

Хадны зургийн судалгаанд өргөн хэрэглэдэг аргачлалаар уг зургуудыг нэгэн хавтгайд байршуулан монгол зургийн аргаар дүрсэлсэн нь сонирхол татаж байна. Хамгийн сонирхолтой нь уг хавтан дээр хил зааг юм уу зам мэт зураасыг маш тодорхой татаж зарим амьтдыг холбож өгсөн явдал юм.

Abstract

IMAGES AND MOTIFS ON THE MANANT KHONDII (SHUI ASHY) PETROGLYPHS OF THE ULAANKHUS SOUM OF BAYAN-ULGII AIMAG

by Gagaa Zolbayar

This article features a panel adorned with rock carvings discovered in the Manant Khondii valley within the Ulaankhus soum of Bayan-Olgii province. The panel exhibits a total of 19 discernible engraved figures, with the prominent representation being that of cattle featuring magnificently large, pointed horns. Notably, the plate portrays a distinct and rare image within the Mongolian Altai rock art tradition—a clearly visible line resembling a “road” or “borderline.”

Keywords: Large panel with petroglyphs, cattle, Mongolian Altai

Ном зүй

Едилхан, Х. (2009). Монгол Алтайн хадны зургийн судалгааны зарим асуудалд. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон диссертаци. УБ.

Цэвээндорж, Д. (2009). Монголын археологийн судалгаа УБ.

Бихумар, Х. (2001). Монголия казахтарынын салт дастури. Өлгий.

Кубарев, В.Д, Цэвээндорж, Д, Якобсон. Э (2005). Петроглифы Цагаан-Салаа и Бага-Ойгура / Монгольский Алтай/. Новосибирск.

